



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар A/364

Хэрлэн сум

Боловсрол, шинжлэх ухааны газрын
бүтцийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.16 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 4 дүгээр сарын 01-ний "Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийн орон тооны жишиг батлах тухай" А/125 дугаар тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/315 дугаар тушаалаар батлагдсан "Аймаг, нийслэлийн Боловсролын газрын үлгэрчилсэн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгт агентлаг Боловсрол, шинжлэх ухааны газрын бүтцийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан бүтцийн дагуу ажилтан, албан хаагчдыг томилох, байгууллагын дотоод журам, ажлын байрчны тодорхойлолтыг шинэчлэн мөрдөж ажиллахыг Боловрол, шинжлэх ухааны газар (С.Мөнхцэцэг)-т даалгасугай.

3. Байгууллагын бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалах төсвийн тооцоог хянаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Өнөрцэцэг)-т даалгасугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны Б/108 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
дугаар сарын-ны
захирамжийн хавсралт

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН БҮТЭЦ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ГАЗРЫН ДАРГА (1)

Статистик тайлан, хяналт-
шинжилгээ, үнэлгээ
хариуцсан алба (10)

Сургалт арга зүй, багшийн хөгжил,
суралцагчийн үнэлгээ, багшийн ес
зүй хариуцсан алба (13)

Байр ашиглалттай холбоотой
ажил үйлчилгээний ажилчин
(6)

Аймгийн Засаг даргын 2022 оны
дугаар сарын 2022-ны
захирамжийн хавсралт

**Боловсрол, шинжлэх ухааны газрын орон тоо
(албан тушаалын нэр, ангилал)**

№	Албан тушаалын нэр, ангилал	Орон тоо	Ангилал, зэрэглэл
1	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга	1	T3-10
2	Статистик тайлан, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албаны дарга	1	T3-7
3	Шинжлэх ухаан, технологи, дээд боловсрол, мэргэжлийн боловсролын сургалт, багшийн хөгжил, эрчин хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
4	Статистик, мэдээллийн сүлжээ, мэдээллийн технологи хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
5	Хүүхдийн хөгжил, хамгаалал, тэгш хамраан сургалт хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
6	Хоол үйлдвэрлэл үйлчилгээ, сургалтын эрчин хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
7	БШУ-ны салбарын төсвийн төлөвлөлт зохицуулалт хариуцсан ахлах эдийн засагч	1	TY-8
8	Хөрөнгө оруулалт, төсвийн гүйцэтгэл хариуцсан эдийн засагч	1	TY-8
9	Ерөнхий нягтлан бодогч	1	TY-8
10	Архив бичиг хэргийн ажилтан	1	TY-5
11	Нярав, номын санч	1	TY-4
12	Сургалт арга зүй, багшийн хөгжил, суралцагчийн үнэлгээ, багшийн ес зүй хариуцсан албаны дарга	1	T3-7
13	Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэргэжилтэн	2	T3-5
14	Анхан шатны боловсрол хариуцсан мэргэжилтэн	2	T3-5
15	Математик, мэдээлэл зүйн судлагдахуун хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
16	Эх хэлний судлагдахуун хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
17	Тогтвортой хөгжлийн боловсрол, байгалийн ухааны судлагдахуун хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
18	Нийгмийн ухааны судлагдахуун хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
19	Технологи, зураг зүйн судлагдахуун, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
20	Дуу хөгжмийн судлагдахуун хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
21	Биеийн тамирын судлагдахуун, насан туршийн боловсрол хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
22	Гадаад хэлний судлагдахуун, сурх бичиг хариуцсан мэргэжилтэн	1	T3-5
Байр ашиглалттай холбоотой ажил үйлчилгээ:			
23	Жолооч-туслах ажилчин	1	TY-3
24	Үйлчлэгч	1	гэрээгээр
25	Харуул хамгаалалт хариуцсан ажилчин	4	гэрээгээр
	Нийт	30	